



Уран зохиол.

ХИЛЧДИЙН ГАВЬЯА БҮДГЭРЭХ УЧИРГҮЙ.

/"Байтагийн од" найраглалын зохиолчтой сэтгүүлч
Г.Дагважамц цөөн хором хөөрөлдөв/



Сурв- Бид хил, хилчний сэдвээр шүлэг, уранзохиол сэтгүүлдээ нийтэлж байгаа юм. Өөрөө энэ чиглэлээр нэлээд бичиж "Эх орны манаа" болон төвийн сонин сэтгүүлд хэвлүүлж байсныг би сайн мэдэх билээ. Энэ удаа таны "Байтагийн од" хэмээх найраглалыг сэтгүүлдээ тавьюу гэсэн юм?

Ш.Д- Тэр бололгүй яахав олон жилийн өмнө тэрлүүлсэн болохоор одоо үзэхэд засах залруулах юм бий л байх. Уг нь хилийн цэргийн ойн уралдаанд зориулан бичиж байр эзлээгүй ч бас ч гэж том найрагчдаас урмын үг сонсож баярлаж явсан юм л даа.

Сурв- Сүүлийн жилүүдэд ажиглаад байхад хилийн цэргийн сэдэвт зохиол туурвил ховор доо юу даа. Тэр дундаа хил, хилчний амьдралыг харуулсан бүтээл алга болсон шиг. . .?

Ш.Д- Ховордуу байгаа нь үнэн. Би ч мөн ингэж бодож харамсаж явдаг. Гэхдээ зохиолчид бичихгүй байгаа биш, гол нь тэр бүтээлийг нь нийтэлдэг, өргөн олонд хүргэдэг хэрэгсэл нь цөөн болсонтой холбоотой болов уу? Одоо харин "Цог" сэтгүүл сэргэлээ, "Хил судлал" сэтгүүл ч энэ сэдвээр бүтээл тавьж хилчид уншигчиддаа хүргэж байгаа нь нэн сайшаалтай хэрэг. Ахмад хилчдийн амь насаараа дэнчин тавьж хамгаалсан эх орны хил, баатарлаг хилчдийн алдар гавьяа бүдгэрэх учиргүй. Тэр дайчин уламжлалыг өнөөгийн залууст өвлүүлэн үлдээх, тэднийг эх орондоо, эрдэнэт хилдээ хайртай үзлээр

хүмүүжүүлэхэд уранзохиолын үүрэг нэн их. Дахин хэлэхэд үүнийг хилчдэд хүргэдэг өдрийн хэвлэл үнэхээр үгүйлэгдэж байна. Өөрөөр хэлбэл бичсэн зүйлээ хаана хэвлүүлэх билээ дээ.

“Эх орны манаа” сонинд л гэхэд манай нэрт зохиолчдоос авахуулаад эхлэн бичигчдийн цэрэг эх орны тэр дундаа хилийн сэдэвт бүтээл байнга нийтлэгдэж байсныг өөрөө эрхлэгч нь байсны хувьд сайн санаж байгаа. Манай хилчид өөрсдөө их бичдэг, нийтлэгдсэн зүйлээ уншаад урамшдаг байлаа шүү дээ.

**Монгол Улсын баатар, хилчин
С.Лхагвадоржид.**

“Тулааны талбарт Байтагийн чулуу
Тулгын тотго шиг халуун байсан юм . . .”

БАЙТАГИЙН ОД /Найраглал/

*Зах ирмэг нь сэмэрсэн ч
Цэвэрхэн эрээн бүтээлгээр
Засч хураасан ор
Цэргийн байранд содохон
Он удсаныг илтгэх
Онгож элэгдсэн бүтээлэгтэй
Орны эзэн эр
Ороод ирдэггүй байгаа.
Санаснаар гэвч үгүй байж
Саяын орны эзэн
Самданжамцын Лхагвадорж
Сайхан орноо хамгаалан
Олны жаргалын төлөө
Од болон харваж
Эрдэнэт хилийн заставтаа
Эргэж дахиад ирсэнгүй.
Алба хаасан застав нь
Алдраар нь овоглож үлдсэн байна.
Ард түмний сэтгэлд
Ариун дүр нь мөрхөнрсөн байна.
Бахархан дууриах үйлстэн
Баатар хилчин Лхагвадоржийн
Байгуулсан гавьяаны заримаас
Багачууддаа ах нь ярья!*

БАЙТАГ УУЛАНД

Баатруудынхаа гавьяагаар нэр нь мөнхөрсөн
Байтаг богд өндөр уул.
Суманд сийчүүлж бие нь шархалсан ч
Шуналтныг алхуулаагүй эрэлхэг уул.
Эрдэнэс баялгаа өвөрлөн дүнхийх
Энэ уулыг намхан гэж эндүүрсэн
Харгис дайсан давж чадаагүй юм.
Хадтай бэлд нь дахин авираагүй юм.
Гэнэтийн явдал болохыг мэдсэн шиг
Үүр цайхгүй удаад байв.
Гэрч нь болохоос айв уу!? Гэлтэй
Үүлэн цаана нар хоргодов.
Сэтгэлд нэгийг шивнэж
Сэвсээ салхин үлээнэ.
Үглээ бяцхан жиргэмэлийн дуу ч үгүй
Бөглүү тайван хил дүнхийнэ.
Салхин аясаар ганхах
Өвсөн толгой алдахгүй
Сайхан нутгийн чулуу
Жаахан хөдлөхийг андахгүй.
Сонор соргог хилчид
Харуулын байрандаа сэргээг!
Сохор шөнийн чимээгүйд
Хавийн юмс дүнсгэр

ТУШААЛ

Дэд хурандаа Зонровын
Гэрийн тооноор гэрэлтэй
Дэлгэсэн газрын зураг руу
Дөрвөн хүн тонгойно.
Шүдээ бараг зэвсэглэсэн
Хорин хэдэн дээрэмчин
Шүтээн болсон нутгийн минь
Хилийн гүнд нэвтэч
Нутгийн ард Гэцэлийг
Моринд чирч хөнөөгөөд
Нүүгдаж одсон мэдээг
Дөнгөж сая авчээ.
Өөр хаагуур ч явахгүй
Яг л үүгээр буцна.
Өглөө явсан тэд
Зайлаад гарчих болоогүй
Ийм учраас яаралтай
Хоёр хэсэг томилж
Их, Бага Хавтагийн

Цаад талаар хааж
Буцах замд нь отож
Зохих шанг нь хүртээе гэж
Буурал үсээ илж
Зонров дарга өгүүлээд
Харандааныхаа үзүүрээр
Газрын зургийг хатгав.
Хаагуур дайсан өнгөрснийг
Цаад нөхөд нь зөвшөөрөв.

Тоорцогийн гоёхон шигтгээ шиг
Одод хулжаан
Тогтуун үдшээр үүрэглэх
Цэцгэс цочоон
Түгшүүр зарлах бүррэн дуу
Сэтгэлд нэгийг шивнэв.
Түргэн авсан хилчид
Шугамд жигдрэн жагсав.
Даргын дуу хүнгэнэж
Хилчдийн нэр дуудлаа.
Дархан хилээ батлах
Хүндтэй үүрэг хүлээлгэлээ.
Үүрэг авсан хилчид
Үдшийн намуунд ергүүлсээр
Хатирч морьдынхоо туурайд
Хатуу чулууг харгиулсаар
Хүрэх тэр газраа
Ирээд байгаа нь энэ
Хүглийх хадат уул
Толгой дээрээс нь өнгийнө.

ОТОЛТ

Гэмгүй номхон ардыг
Өрөвдөх сэтгэлгүй яргалан
Гэр орныг нь цөлмөн
Өвөр түрийгээ дүүргээд
Санаа хүсэл нь ханасан
Хилийн чанадахь дээрэмчид
Сайхан нутгийг минь бузарлаж
Сажлуулж яваа нь харагдав.
Буцах замаа буруулж
Ум хумгүй яваа
Бусдын жаргалыг хөнөөгч
Унаатай тэднийг хараад
Даяар чөлөөтэй орны минь

Дархан хилд халдвал
Ямар шийтгэл хүлээлгэдгийг
Яргачдад одоохон үзүүлье гэж
Отож хүлээсэн хилчдийн
Омог хилэн бадарч
Бушуухан тонилгох хүслээр
Буугаа чанга атгав.
Үхэл амьдрал хоёр
Хутганы ирэн дээр тэнссэн
Нэхэл хатуу тулаан
Энд ингэж болсон юм.

ТУЛАЛДААН

Мэргэн уулын сугаар
Сэмхэн нэвтрээд гарчихна гэж
Сэрэмж суларсан дайсан
Сэжиг авсан янзгүй.
Буцах газаргүй болсон
Тонуул хулгай тэднийг
Бууны сумнаас өөр
Тосч юу угтах билээ.
Гэлдэрч явсан дайснууд
Гэнэтийн отолтод цочирдсон ч
Газрын хаванг овжин ашиглаж
Галлаж эхлэв, хилчид рүү.
Тоогоор давуугаа мэдсэн
Харийн дээрэмчдийн сум
Толгой дээгүүр шунгинаж
Амь эрэн исгэрэхэд
Өсөж төрсөн нутгаа
Өстнөөс өмөөрөн тулалдах
хилчин эрсийн зориг
Үхлээс үл шантарна.
Хашир хилч лхагвадорж
Хамт хориглосон гуравтайгаа
Онх холбон буудаж
Олноос тавыг хороов.
Хэсэг буудалсны эцэст
Хилчин байлдагч Намсрай
Үхлийн шарх олсон ч
Үг хэлэх санаатай
Алаг хоёр нүдээ
Алгуур нээж хараад
Өстөн дайсныг устгаж
Өшөөг минь аваарай гэх шиг
Тогтуун харцаар даргаа харснаа
Толгой нь алгуур гудайлаа.

Насан залуу баатар
Намсрайг онож алсандаа
Бах нь ханасан дайсан
Хадны цаанаас цухуйлаа.
Барьсандаа алдаж үзээгүй
Бат мэргэн онодог
Офицер Лхагвадоржийн суманд
Ориж унах нь харагдав.
Балмад дайсны суманд
Бас нөгөө нь өртөхөд
Бага түрүүч хоёулхан
Лхагвадорж үлдлээ.
Эх нутгаа өмөөрсөн
Эр зориг нь буцалж
Олны өвдөөс хоёул
Огтхон ч эмээлгүй тулалдсаар. . .
Дайрахаа дээрэмчид зогсч
Тулаан түрхэн амсхийв.
Дахиад довтлохыг нь хүлээж
Сумаа хоёул хуваав.
Уул хад нурах шиг
Нүргэлэх чимээ намдасхийж
Ус буцлам халуунд
Дарийн үнэр ханхална.
Сарнисан хүчээ эмхэлж
Дээрэмчид улайран дайрлаа.
Сандарч ер тэвдэлгүй
Лхагвадорж маань ч галлав.
Тэгтэл . . . тэгтэл гай дайрч
Тэнэсэн сум нэгийг нь онолоо.
Атаатан дайсны дунд
Ахмад ганцаар хоцров.
Ариун газар шороо
Алаг сайхан цэцэгс
Хайртай нутгийн нь баялаг бүхэн
Хажуу талаас нь тулж
Эх оронтойгоо цуг байхад
Эр цэрэг алздаггүй ээ.
Тэнхээ хүчээ сэлбэж
Тэрслүү дайсныг ниргэдэг билээ.
Хэрмэл тэнүүл тэдсэн бол
Хэдийнээ гараа өргөх байсан.
Сохор зоосны үнэгүй амиа
Сөхөрч унаад гүйх байсан. . .
Ганцаар үлдэхийг мэдсэн
Дайсан шаргуу дайрлаа.
Газрын бартааг ашиглаж
Амьдаар барихыг оролдов.

Хар сахалт хасаг
Хамгийн түрүүнд мөлхөнө.
Хөмхий зуусан түүний
Хөлөрсөн дух гялаина.
Ар монголын офицерыг
Амьдаар барина гэхээс
Авах шагналд нүд нь
Эрээлжлэв бололтой.
Алдар хүндэд хөл нь
Солбив бололтой.
Ахиад таван хасаг
Араас нь явж харагдана.
Цэцэн бууддаг нүдийг нь
Ухаж нохойд хаяя.
Цээжинд лугших зүрхийг нь
Сугалж тугаа тахъя.
Бүлээн халуун цусыг нь
Бүргэдүүддээ нэг амсуулъя.
Цусаа үзээд улайрдаг
Монгол хүний зан.
Цугаараа яваад түүнийг
Барьж хүлээд ир! гэж
Залуухан атаман дарга нь
Зандарч тушаасан байлгүй.
Өөрийг нь барих санаатай
Өвдгөө цоортол мөлхөх
Өгөр царайт хасаг
Өндрөөс тодхон үзэгдэнэ.
Гарцаагүй барих нь гэхээс
Бах ханасан тэр
Гартаа хэрсэн оосрыг
Тайлж байгаа нь харагдав.
Шагайсан бууны нь хараанд
Торойтол ороод ирлээ.
Шангаа ав май! гээд
Гохоо алгуур дарлаа.
Тархиа хага буудуулсан
Тарган хасаг овгосхийгээд
Аягүй дуу гаргаснаа
Алгуур доош гулсав.
Барих оролдлого нь саатсанд
Багтарч уурласан дарга нь
Яаруулж байгаа бололтой
Яхир дуу нь хадлаа.
Баатар зоригт хүүгээ
Балмад дайнаас өмөөрөв үү?
Байц сүрлэг хадад
Барайж харлаад сүртэй.

Туйлдаж цөхрөөд дайсан
Тугалган мөндөр буулгалаа.
Баруун мөр нь нойтон оргиход
Барьж үзвэл цус. . .
Хондон улаан цус
Цамцыг нь нэвтлэн урсаж
Хонгор хүүгийн нь уруул шиг
Цэцгийн толгой будав.
Эх орны эрэлхэг хүү
Сандарч ер тэвдсэнгүй.
Эргэлзэж огт гайхсангүй.
Цамцаа цуулж боолоо.

ЭЦСИЙН МӨЧ

Дайсанд үхэл шагнах
Сум нь даанч цөөрч
Даацтай мэргэн буудахад
Тар нь дахиад шархдав.
Эр зоригоо үзүүл гэж
Эцэг нь хөмсөг зангидах шиг
Эргэн тойрны уулс
Сүр нэмэн дүнхийнэ.
Хээнцэр ганган цэцэгс
Намайг авраач гэх шиг
Хээрийн зөөлөн салхинд
Үл мэдэг бөхөлзөнө.
Хоёр шарх олсон ч
Хортныг нааш алхуулалгүй
Дайчны үүргээ Лхагвадорж
Даамай үнэнч биелүүлсэн юм.
Шархадсан мөр нь эмзэглэвч
Шантарч зориг нь мохоогүй ээ!
Айж хулчийж үзээгүй
Амгалан царай нь л цонхийжээ.
Үлдсэн бүх сумаа
Тоолж үзээд Лхагвадорж
Буруу санасан дайсан руу
Буугаа дахиад онилов.
"Өрссөн нь л хожих эгзэгтэй үед
Сум хоосон гарздана гэдэг
Өргөсөн ариун тангарагаасаа
Ухарч няцсанаас юуны өөр!
Замагт буу дуугарсан бол
Заавал дайсан үхэх ёстой.
Заяа тэнгэр нь л хаяагүй бол
Зандалчдыг энд дуусгах ёстой.
Энэ хэдэн сумаа

Эзэнд нь хүргээд үхье.
 Эгэл бие амьсгаатай байхад
 Эдэнд амьдаар баригдахгүй.
 Хайрлах сэтгэлгүй дээрэмчид
 Ойртохдоо улам сайн
 Хамгийн сүүлчийн сумаа
 Өөртөө . . . гэж бодод
 Тамирдсан биеэ хүчлэн
 Лхагвадорж маань өндийв.
 Тандаж хүлээсэн дайсан
 Гогоо яг дарав.
 Үхэл тээсэн төмрийн хэлтэрхий
 Үнэнч хүүг минь онолоо гэж үү!
 Үүлгүй тэнгэрт аянга гялбах шиг
 Сүүлгүй чононууд алчихлаа байна шүү!
 Өлгий нутгийнхаа хөрсөнд
 Өстний хөл гишгүүлэхгүй гэж
 Хиргүй сэтгэлээр тангараг тавьсан
 Хилчний албандаа үнэнч гэсэн шиг
 Атаатан дайсныг дальдруулдаг
 Алаг хоёр нүд нь
 Хан тэнгэрийн хаяа ширтэж
 Хараатай хэвээр байв.
 Эх орон хэнээр мануулснаа
 Энд дахин үзэж
 Ахмад Лхагвадорж хэн болохоо
 Ард түмэндээ харуулсан юм.
 Зулай төвнөн ээсэн
 Зургаан сарын нар
 Баруунаа хэлбийж ирэхүй
 Бараан үүл толгойлов.
 Аадрын догшин үүл
 Хуран хуран байснаа
 Аянга цахилгаан нүргэлж
 Усан бороо цутгав.
 Айлын хотонд өнгийх
 Өлөн ховдог чоно шиг
 Араа шүдээ ярзайлгаж
 Өлзийт хилд минь халдахдаа
 Өссөн нутгийн шороо
 Алтнаас ч үнэтэй байдгийг
 Өөрийн нутаггүй хэсүүл
 Харийн зандалчид мэдээгүй биз!

ТӨГСӨЛ

Ээжийн хонгор үрс
Хичнээнч удаа ингэж
Эх орныхоо төлөө
Хэрэм болон зогсч
Наран доорх үнэтэй бүхнээ
Насан залуу биеэр аварч
Эргэж олдохгүй амиа
Эх орондоо өргөв дөө.
Сая ард минь түвшин жаргалтай
Саруул нутгийнхаа хилд одоо
Дальдарч цавчраагүй хурц хараагаар
Дайсныг сэрэмжлэх хилчид маань сэргээ!

Шанжмятавын Доржбал.

Сумангаас ирүүлсэн шүлэг.

Ахлагч Д.Гантөмөр.
/Булган. Тэшиг. . . хилийн дугаар сумангийн хилчин/

* * *
Нагиж дарвиж, найзалж явсан
Нас чацуу нөхдөө мартахгүй
Наадмын өдөрч хилээ манаж
Найрын үед ч үүргээ гүйцэтгэж
Хилтэйгээ хамт нэр нь мөнхөрсөн
Хэдэн бор ахлагчаа би мартахгүй.

Эр нөхрөө дагаж торгон хилд амьдрахдаа
Эгэл бие сэтгэлээрээ нутгаа хамт маналцсан
Энхрий ялдам ааштай ч эрэлхэг зоригтой
Энэ сумангийн бүсгүйчүүдээ би мартахгүй.

* * *

УНДАРМАА

Харахад санаанд ялдамхан
Ханилаад суухад түшигтэй
Халхын сайхан бүсгүй
Хайр ундарсан сэтгэл

Чи миний хань.

Зөн билгийн хурыг
Цээжин дотор минь асгасан
Зүрх сэтгэлийнхээ илчийг
Зөвхөн наddaа зориулсан

Чи миний хань.

Шувуу буцах намраар
Намайгаа л гэж хоцорсон
Шуугиад л буцаад ирэхэд минь
Нартайгаа хамт тоссон

Чи миний хань.

Яруу тансаг шүлээнд мөнхөрсөн

Ундармаа

Янаг сэтгэлийн хайранд жаргасан

Ундармаа

Халх нутгийн сайхан бүсгүй

Ундармаа

Хамтдаа дэвжих амьдралын минь хань

Ундармаа.

